

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ТАЙЛАН

92

2015 оны 02-р сарын 23

Улаанбаатар хот

Тайлант жилийн хугацаанд ТУЗ нь 9 гишүүний бүрэлдхүүнтэй, хянан шалгахын 1 гишүүний бүрэлдхүүнтэй ажиллалаа. ТУЗ-ийн шийдвэрийг тогтоол хэлбэрээр гаргаж ажиллалаа.

“Жуулчин говь” ХК нь 2014 оны 4-р сарын 29-нөөс жуулчин хүлээн авах бэлтгэл ажилдаа орж улмаар үйл ажиллагаагаа 5-р сарын 08-наас 10-р сарын 06-ныг хүртэл улирлын чанартай явуулж, гадаад, болон дотоодын жуулчин, гэрээт компанийн ажилтанд үйлчилж ирлээ.

Үйл ажиллагаа эхлүүлэхийн тулд ТТТранс ХХК-иас 24,859.100 төгрөгний хөрөнгө оруулалтын зээл авсан байна. 2011 оны хөрөнгө оруулалтын зээлийн үлдэгдэл 43,000.000 төгрөг байна.

2014 оны үйл ажиллагааны тайлангаас харахад 2014 онд авсан зээлээсээ 5,000.000 төгрөгийг барагдуулсан байна. Мөн жилийн эцсийн балансаас харахад 6,620.422 төгрөгийн ашигтай ажиллажээ. Одоо ТТТранс ХХК-д 2011 оны зээлийн үлдэгдэл болох 43,000.000 төгрөгтэй нийлээд нийт 62,859.100 төгрөгний зээлийн үлдэгдэлтэй байна. Жуулчин говь ХК нь тайлант жилийнхээ хугацаанд оногдсон татвар болох НДШ, НӨАТ, ААНОАТ, ХХОАТ мөн цахилгаан, ус, газрын төлбөрийг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд татварын ямар нэг хуримтлагдсан өр төлбөргүй ажиллалаа.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан журмын дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажлыг явуулж ирсэн бөгөөд ажлын шаардлагын дагуу:

- Компанийн дотоод хяналтын журам
- ТУЗ-ийн ажиллах журам
- Мэдээллийн үйл ажиллагааны журмуудыг сайжруулж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж мөрдөж ажиллана.

2014 оны үйл ажиллагааны байдлаас харахад авсан зээлээ барагдуулаагүй зээлийн үлдэгдэлтэй байгаа учир ногдол ашиг тараах боломжгүй байна. Цаашид компанийг ашигтай ажиллуулах боломжийг эрэлхийлэн ажиллана.

ТУЗ-ийн дарга

Д. Мөнхсайхан

Хаяг: Ажнай корпорац, Чингисийн өргөн чөлөө-36, Хан-уул дүүрэг
Утас : 345959, Факс: 345959
E-майл: info@juulchingobi.com

